

БАНКНЫ САЛБАРЫН СЕКТОРЫН СУДАЛГАА

АГУУЛГА

1. Хураангуй.....	4
2. Өөрчлөлтийн дохио.....	5
2.1 Банкны салбарын санхүүгийн үзүүлэлтүүд.....	5
2.2 Хууль, эрх зүйн өөрчлөлтүүд.....	9
3. 2025 оны хүлээлт.....	10
3.1 Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал.....	10
3.2 Монгол Улсын эдийн засгийн төлөв.....	12
3.3 Хууль, эрх зүйн өөрчлөлт.....	14
4. Шилжилт.....	15
5. Банкны салбарын эрсдэлүүд.....	18
6. Эрсдэлийг бууруулах шийдлүүд.....	19

1. Хураангуй

Сүүлийн жилүүдэд банкны салбар асар хурдацтайгаар өөрчлөгдөж байна. Дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн асуудал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сорилтууд, сорилтыг даван туулахад туслах технологийн шийдэл, хууль эрх зүйн өөрчлөлт, тогтвортой хөгжлийн төлөөх шилжилт, дижитал дисторшн зэрэг нь салбарыг асар хурдацтайгаар өөрчлөлтөд дасан зохицох шаардлагыг бий болголоо.

Бид банкны салбарын секторын судалгааг 2022 онд анх танилцуулахдаа банкны салбарт гарч буй дэлхийн тренд өөрчлөлтүүдэд Монголын банкнууд хэрхэн дасан зохицох, банкирын ажлын байрны өөрчлөлтийн талаар түлхүү бичсэн. Энэ удаагийн судалгаагаар дэлхий болон МУ-н ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдал болон үүнийг дагаад банк, санхүүгийн салбарт гарч буй өөрчлөлтүүд эдгээрийн манай улсын банкны секторт хэрхэн шууд болон шууд бус замаар нөлөө үзүүлж болох талаар онцоллоо.

Сүүлийн 2 жил системийн нөлөө бүхий банкнууд амжилттай хувьцаагаа олон нийтэд арилжаалах замаар өөрийн хөрөнгийг 487 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ. Дээр нь сүүлийн 5 жилийн хугацаанд банкны салбар үр ашигтай ажиллаж технологийн шинэчлэл болон бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөлжилтийг эрчимтэй хийж байна. Үүнтэй зэрэгцээд банкны ашиг нэмэгдэж 2024 оны эцэст системийн нөлөө бүхий банкнуудын өөрийн хөрөнгийн өгөөжийн дундаж 20 хувьтай байх хүлээлттэй байгаа бөгөөд ирэх жилүүдэд ч хөрөнгийн өгөөж өндөр хадгалагдахаар байна.

Банк, банк бус санхүүгийн зах зээлийн өрсөлдөөн нэмэгдэж байна. Технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж буй банк бус санхүүгийн байгууллагууд, төлбөрийн систем нийлүүлэгч компаниуд, төлбөр тооцоог богино хугацаанд одоо аваад дараа төлөх нөхцөлтэй үйлчилгээний байгууллага асар хурдацтайгаар нэмэгдэж байна.

Монгол улсын хувьд банканд данстай иргэдийн тоо, болон онлайн банк, мобайл

банкны хэрэглэгчдийн хувь хэмжээгээр буюу санхүүгийн байгууллагын хүртээмжтэй байдлын үзүүлэлтээр дэлхийд тэргүүлж байна. Гэвч иргэд, аж ахуйн нэгжийн авч буй санхүүгийн үйлчилгээний тоо цөөн байна. Энэ нь харилцагчийн төлөв, амьдралын хэв маягийг таньж мэдэх, түүнд тохирсон санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлэх замаар санхүүгийн хүртээмжийн гүнзгийрлийг нэмэгдүүлэх боломжтойг харуулж байна.

Хиймэл оюун ухаанд тулгуурлан харилцагчийн төлөв, үйл хөдлөлийг судалж санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү оновчтой болгож байна. Түүнчлэн, хиймэл оюун ухааныг банкны дотоод үйл ажиллагааг сайжруулахад ашиглаж бүтээмж, үр ашгийг дээшлүүлэхэд түгээмэл хэрэглэж байгаа нь банкны салбарыг төсөөлснөөс ч хурдан хугацаанд өөрчилж байна. Иймд дэлхийн тренд, дотоодын эдийн засаг, хууль эрх зүйн өөрчлөлтийг сайтар судалж өөрийн онцлогт тохирсон шинэчлэлтийг цаг алдалгүй хийх шаардлага улам өндөрссөөр байна.

Эхний бүлэгт банкны салбарын санхүүгийн үзүүлэлтүүд болон банкны салбарт хийгдсэн хууль, эрх зүйн орчны талаар харуулах бол дараагийн бүлэгт Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдал болон дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал болон ирээдүйд хийгдэх хууль, эрх зүйн өөрчлөлтийн талаарх үзүүлнэ. Гуравдугаар бүлэгт банкны салбарын дэлхийн тренд өөрчлөлтийн талаар харуулна. Эцсийн 2 бүлэгт банкны салбарт ирэх 2025 онд тулгарч болох эрсдэл болон түүнийг хэрхэн шийдвэрлэх боломжтойг харуулах юм.

2. Өөрчлөлтийн дохио

2.1 Банкны салбарын санхүүгийн үзүүлэлтүүд

Банкны салбар нь 2004 оноос хойш жилд дунджаар 24%-ийн өсөлттэй байна. Банкны салбарын өсөлтөд уул уурхайг дагасан эдийн засгийн мөчлөг, төрөөс хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд ихээхэн нөлөөлжээ. Сүүлийн 4 жилийн хугацаанд технологийн дэвшил, технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг банкнууд эрчимтэй хөгжүүлж хэрэглэгчдэд хурдан шуурхай, хялбар санхүүгийн үйлчилгээг хүргэхэд ихээхэн дэвшил гаргалаа.

Энэхүү хэсэгт банкны салбарын 2019 оны санхүүгийн голлох үзүүлэлтийг 2025 онтой харьцуулан тайлбарлахыг зорилоо. Банкны салбарын санхүүгийн үзүүлэлтийг нийлмэл жилийн өсөлтийн хувь (CAGR)-р харуулах нь хөрөнгө оруулагчдад тус салбар нь хэрхэн үр ашигтай тогтвортой өсөж буйг харуулах чухал ач холбогдолтой гэж үзсэн. /Зураг 1/

Банкны салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 2019 онд 7%-тай байсан бол 2024 онд 20%-тай байхаар хүлээгдэж байна. Банкны салбарын “Шинэтгэлийн хөтөлбөр”-ийг 2020-2023 оны хооронд хэрэгжүүлсэн. Хөтөлбөр нь 1) Банкны салбарын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, эрсдэл даах чадварыг сайжруулах, 2) Олон нийтийн өмчид шилжих замаар банкнуудад тавих хөндлөнгийн хяналтыг нэвтрүүлж, үйл ажиллагааг ил тод байлгах, зохистой засаглалыг буй болгоход чиглэсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд системийн нөлөө бүхий банкнууд 2022 оноос эхлэн олон нийтэд хувьцаагаа санал болгож нээлттэй компани болох замаар өөрийн хөрөнгийн хэмжээг 447 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн. Дээр нь сүүлийн жилүүдэд технологийн тусламжтайгаар ажилчдын бүтээмжийг дээшлүүлж хэрэглэгчдэд хурдан шуурхай, хялбар үйлчилгээг санал болгож буй нь зардлын үр ашигтай байдлыг нэмэгдүүлжээ.

Нийт хөрөнгийн өгөөж 2019 онд 0.7% байсан бөгөөд тухайн үед эдийн засгийн салбарууд агшиж түүнийг дагаад банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж эхэлсэн нь зээлийн эрсдэлийн зардлыг өсгөсөн. Дээр нь

үйл ажиллагааны зардал их, хүүгийн маржин доогуур байсны улмаас нийт хөрөнгийг үр ашигтай ашиглалт харьцангуй доогуур байжээ.


Харин 2024 оны байдлаар харахад нийт хөрөнгийн өгөөж нь 2.1%-д хүрчээ. Ийнхүү нийт хөрөнгийн өгөөж нэмэгдэхэд 2021 оноос эхлэн цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах, эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрийн зээл болон өөрийн эх үүсвэрээр олгох зээл тогтмол нэмэгдсэн нь хүүгийн орлогыг нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлсэн. Дээр нь банкнууд технологийн шинэчлэлийг эрчимтэй хийж технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимаар хийх боломжийг бүрдүүлсэн нь хүүгийн бус орлогыг өсөлтийг буй болголоо. Ийнхүү үйл ажиллагааны орлогын хөрөнгөд харьцуулсан хувь хэмжээ 2019 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдэж 10%-д хүрчээ.

2019 онд хүүгийн бус орлогын 40% нь зардалд зарцуулагддаг байсан бол технологийн шийдлийг үйл ажиллагаандаа идэвхтэй ашигласнаар ажилчдын бүтээмж нэмэгдэхийн зэрэгцээ үйл ажиллагааны зардал буурч 2024 онд хүүгийн бус орлогын 25% нь үйл ажиллагааны зардалд ашиглагдаж байна. Ийнхүү зардлын CAGR 10% байна.

Эдийн засгийн салбарууд 2019 оны эхнээс эхлэн агшиж тэр хэмжээгээр бизнесийн зээлийн чанаргүйдэл нэмэгдсэн нь банкны салбарын эрсдэлийн зардлыг нэмэгдүүлж байсан бол 2022 оноос эхлэн эдийн засгийн салбарууд идэвхжихийн хэрээр бизнесийн зээлийн чанаргүйдэл буурч эхэлсэн нь эрсдэлийн зардлыг буурахад чухал хувь нэмэр оруулсан. Нөгөө талаас олон нийтэд нээлттэй болохтой холбоотойгоор активын чанарын үнэлгээг хийж зээлийн эрсдэлтэй холбоотой менежментийг оновчтой хэрэгжүүлж активын чанарыг сайжруулсантай холбоотой.

Үйл ажиллагааны орлого өсөж, эрсдэлийн зардал буурах нь банкнуудын өөрийн хөрөнгийн ашиглалт нэмэгдэхийн хэрээр банкнуудын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө улам бүр нэмэгдэж жил бүр улсад төлж буй татварын хэмжээ тогтмол өссөн байна.

Зураг 1. “Банкны салбар сүүлийн 5 жилийн хугацаанд үр ашигтай, тогтвортой өсөлттэй ажиллаж санхүүгийн зах зээлд чухал үүрэг гүйцэтгэж байна.”



Эх сурвалж: Банкнудын вэб хуудсан дээрх санхүүгийн мэдээлэл дээр тулгуурлан, судлаачид тооцов

Банкнудын төлж буй татварын хэмжээ 2019 онд татварын өмнөх ашгийн 24%-тай тэнцэж байсан бол 2024 онд 37%-тай тэнцэх болжээ.

Банкны салбар нь өөрийн 1 төгрөгийг ашиглан 10 төгрөгтэй тэнцэх хэмжээний зээл, хөрөнгө оруулалт болон бусад төрлийн үр ашигтай үйл ажиллагаанд хөшүүрэг байдлаар ашиглаж байна. Хөшүүргийг 2019 онтой харьцуулахад нийлмэл жилийн өсөлтийн хувь 1% байгаа нь харьцангуй бага үзүүлэлт хэдий ч цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан эдийн засгийн мөчлөгийн үе таарсан, зээлийн эрэлт 2020, 2021 онуудад бага байсан, дээр нь учирч болзошгүй эрсдэлтэй холбоотойгоор зохицуулалтын орчин чангарсан зэрэг нь ихэвчлэн нөлөөлжээ.

Системийн нөлөө бүхий банкнуд 2022 оноос эхлэн хөрөнгийн зах зээлд нээлттэй болсноор хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээг 2021 онтой харьцуулахад 102% орчим хувиар нэмэгдүүлэхээс гадна хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 48%-ийг дангаар бүрдүүлж байна.

Банкны салбарын санхүүгийн үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой, өөрийн хөрөнгийн өгөөж сүүлийн 3 жилийн хугацаанд 20% орчимд хадгалагдаж буй хэдий ч хөрөнгийн биржид бүртгэлтэй худалдаа, үйлдвэрлэл, тээвэр логиستيкийн салбарын компаниудтай харьцуулахад хувьцааны P/B харьцаа нь доогуур буюу дээрх салбаруудтай харьцуулахад илүү хямдхан хямдхан байгааг илтгэж байна.

Манай улсын хөрөнгийн зах зээлд оролцогчийн бүтцийг харахад гадаадын хөрөнгө оруулагчид бага, багцын хөрөнгө оруулалт хараахан хөгжөөгүй ихэвчлэн жижиг хөрөнгө оруулагчид байна. Иймд банкны салбарын ашигт ажиллагаа, засаглалын тогтолцоо, өрсөлдөх чадвар бүс нутагт харьцангуй өндөр байгаа талаар мэдээлэл дутмаг байна. Иймд банкнуд хөрөнгө оруулагчдад ашигт ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтийн талаар тогтмол мэдээлэх, хөрөнгө оруулагчидтай харилцааг сайжруулахаас гадна өөрийн активын чанарыг хэрхэн сайжруулж байгаа талаар хөрөнгө оруулагч нарт тохирсон мэдээллийг тогтмол өгч байх шаардлагатай байна.

	Хаан банк	ХХБ	Голомт банк	Төрийн банк	Хас банк
Хувьцааы анхны үнэ	959	33,000	1,285	590	677
2023 эцэс	1204	33,500	906	559	569
2024 оны 3 дугаар улирал	1,010	24,540	1,087	470	761
Анхны үнээс өөрчлөгдсөн хувь	5%	-26%	-15%	-20%	12%


Нөгөө талаас хөрөнгө оруулагчид эдийн засгийн тодорхой бус нөхцөл байдлаас шалтгаалан банкны салбарын чанаргүй зээл нэмэгдэх, үүнийг дагаад банкны ашигт ажиллагаа буурах, санхүүгийн зах зээлийн өрсөлдөөн улам бүр нэмэгдэх нь банкны салбарт сорилтыг дагуулах болон зохицуулагч байгууллага болон төрийн зүгээс авч хэрэгжүүлэх хууль, эрх зүйн арга хэмжээ нь банкны салбарт нөлөөлөх зэрэг эрсдэлүүдийг тооцож байгаа нь харагдаж байна.

Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах, эдийн засгийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрийн нөлөөгөөр 2019 оноос эхлэн агшаад байсан банкны салбарын зээл олголт нэмэгдэж эхэлсэн. Дээр нь банкнууд хувьцаат компани болж өөрийн хөрөнгийг нэмэгдүүлсэн нь банк өөрийн эх үүсвэрээр эдийн засгийн салбаруудыг дэмжих, эдийн засгийн сэргэлтийн хурдасгахад чухал нөлөө үзүүлсэн

2021 оноос эхлэн худалдаа, үйлчилгээний салбар харьцангуй сэргэж эхэлсэн бол 2022 оноос эхлэн уул уурхай, түүнийг дагасан тээвэр, худалдаа үйлчилгээний салбар эрчимжиж тэдгээр салбаруудад олгох зээл олголт нэмэгдсэн. Банкны системийн иргэд, бизнес эрхлэгчдэд олгосон зээлийн хэмжээ 2024 онд ДНБ-ийн 44%-тай тэнцэхээр хүлээгдэж байгаа бөгөөд нийлмэл жилийн өсөлт хувь (CAGR) нь 14% байна.

Зээлийн багцын ДНБ-д эзлэх хэмжээ буурсан нь эдийн засгийн идэвхжил нэмэгдсэн, салбаруудын сэргэлт харьцангуй хурдан байгаатай холбоотой. 2020 онд нийт зээлийн багцыг иргэд болон байгууллагын зээл ижил хэмжээтэйгээр бүрдүүлж байсан бол 2022 оноос цалин, тэтгэвэр аажмаар нэмэгдсэн нь иргэдийн зээл авах боломжийг нэмэгдүүлсэн. Нөгөө талаас хэрэглээний зээлийг технологид суурилсан байдлаар хурдан шуурхай, хялбар олгож буй нь иргэдийн зээлийн өсөлтийг нэмэгдүүлж 2024 оны байдлаар нийт зээлийн 60% нь иргэдэд олгогджээ.

Зураг 2. “Эдийн засгийн сэргэлтийг дэмжихэд банкны салбарын зээлийн өсөлт чухал нөлөө үзүүлсэн.”



Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо болон судлаачдын тооцоолол

Банкнудын зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь сүүлийн 5 жил тасралтгүй буурлаа. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан уул уурхай, барилга, боловсруулах салбарын зээлийн чанаргүйдэл 2020 онд өндөр байсан бол хэрэглээний зээлийн чанаргүйдэл харьцангуй нам дор түвшинд байлаа.

Эдийн засаг аажмаар сэргэхтэй зэрэгцэн зээлийн чанаргүйдэл аажмаар буурч ирсэн бол сүүлийн 2 жилийн хугацаанд эдийн засаг сэргэсэн, зээл олголт нэмэгдсэн нь чанаргүй зээлийн хэмжээнд нөлөөлсөн бөгөөд 2024 оны төгсгөлд чанаргүй зээлийн хувь хэмжээ 6%-тай байхаар байна.


Зээл, хадгаламжийн хүү сүүлийн нэг жилийн хугацаанд харьцангуй тогтвортой байна. Цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах бодлогын арга хэмжээний үр дүнд хадгаламжийн хүү буурахын зэрэгцээ зээлийн хүү 2021 онд түүхэн доод хэмжээнд буюу 13.6%-д хүрсэн.

Хугацаагүй хадгаламж, харилцах дансанд хүү тооцохыг зогсоосныг болиулсан, мөн инфляцын дарамтаас үүдэн бодлогын хүүг 2022 оноос удаа дараа нэмсэн нь эх үүсвэрийн зардал нэмэгдэх гол шалтгаан болсон.

Нийлүүлэлтийн гаралтай инфляцын түвшин буурч эхэлснээр 2024 оны эхнээс бодлогын хүүг гурван удаа нэгж хувиар бууруулж 2024 оны 3 улирлын байдлаар 10%-д хүргэв.


Ийнхүү бодлогын хүү буурсны нөлөө хадгаламжийн хүүд шууд нөлөөлөхгүй хэдий ч тодорхой хугацааны хоцрогдолтойгоор нөлөөлнө. Ингэснээр зээлийн өртгийг бууруулах, хөнгөлөлттэй зээлийг дахин санхүүжүүлэх тохиолдолд зээлдэгчдэд ирэх дарамтыг багасгах зэргээр эергээр нөлөөлөхөөр байна.

Зураг 3. “Зээлийн хүү буурах орон зай бага байна.”



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4. “Төгрөгийн бодит өгөөж сулрах эрсдэл нь банкны эх үүсвэрийн долларжилт буй болох, төгрөгийн хадгаламж буурах эрсдэлийг дагуулж байна.”



Эх сурвалж: Монголбанк

2024 онд нийт банкны пассив өмнөх оноос 10%-аар нэмэгдэж 58 их наяд төгрөгт хүрэх хүлээлтийг үүсгээд байна. Харилцах, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2022 оны эхнээс аажмаар өсөхтэй зэрэгцэн банкны эх үүсвэр мөн адил нэмэгдсэн. Гэвч геополитикийн хурцадмал байдал, тээвэр логиستيкийн хүндрэлээс үүдэлтэйгээр нийлүүлэлтийн гаралтай инфляц нэмэгдсэн нь төгрөгийн бодит өгөөжийг бууруулж ингэснээр төгрөгийн хадгаламж буурч долларын хадгаламж нэмэгдэх нөхцөл байдлыг буй болгосон. Гэсэн хэдий ч 2022 оны сүүлээс эхлэн инфляц аажмаар буурч төгрөгийн хадгаламжид итгэх итгэл нэмэгдсэнээр төгрөгийн хадгаламжийн өсөлт 2023, 2024 онд үргэлжиллээ.

Төгрөгийн бодит өгөөж нэмэгдсэн нь төгрөгийн харилцах болон хадгаламжийг нэмэгдүүлсэн бол нөгөө талдаа долларын харилцах болон хадгаламж буурчээ.

Ирэх 2025 онд төсөв тэлэх, томоохон бүтээн байгуулалтын төслүүд хийгдэхээр байгаа нь төлбөрийн тэнцэл, валютын ханш болон инфляцад дарамт учруулах эрсдэл өндөр байна. Энэ нь эргээд иргэдийн дунд төгрөгт итгэх итгэл буурах, төгрөгийн эх үүсвэр татахад ихээхэн хүндрэл учрах эрсдэлийг үүсгэж байна. Цаашлаад эх үүсвэр долларжих, зээлийн хүүгийн зардал нэмэгдэх эрсдэлийг мөн дагуулж байна.

2.2 Хууль эрх, зүйн өөрчлөлтүүд

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдлын эхэн үеэс банкны салбар нь эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чухал нөлөө үзүүлж буй талаар өмнө нь дурдсан. Иймээс банкны салбарын ил тод байдлыг нэмэгдүүлэх, хувь эзэмшлийг бууруулах чиглэлд томоохон өөрчлөлтүүдийг сүүлийн 4 жилийн хугацаанд хийжээ. Үүнд:

- “Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-ийг 2020-2023 оны хооронд хэрэгжүүлэв. Банкны салбарын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, эрсдэл даах чадварыг сайжруулах, олон улсын жишгийн дагуу өмчлөлийг олон нийтийн өмчийн хэлбэрт шилжүүлэх замаар банканд тавих хөндлөнгийн хяналт шалгалтыг нэвтрүүлэх, зохистой засаглал, засаглалын ил тод байдлыг нэмэгдүүлэх, цаашлаад олон улсын стандарт сайн туршлагад нийцсэн зохицуулалтын эрх зүйн орчин бүрдүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх зорилгоор 5 зорилтыг тавин тус хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.
- Банкнууд хувьцаагаа олон нийтэд амжилттай арилжаалав. Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 4.2 дахь хэсэгт “Банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани, бусад банк нь хувьцаат компани” гэж заасны дагуу системийн нөлөө бүхий банкнууд 5-11 хувийн хувьцаагаа олон нийтэд санал болгож 447 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэв. Ийнхүү банкны салбарыг олон нийтэд нээлттэй болгох, олон улсын хөрөнгө оруулалтыг татах боломжийг нээх боломжийг бүрдүүлэв.
- Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд гадаадын төрөлжсөн банкны үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой заалтуудыг тусгаж өгөхөөс гадна зохицуулагч байгууллагын зүгээс холбогдох дүрэм, журмыг боловсруулсан нь манай улсын санхүүгийн зах зээлд чухал алхам болов.

Засгийн газраас “Зээлийн хүүг бууруулах стратеги 2020-2024”-ийг хэрэгжүүлсэн. Энэхүү стратегийн хэрэгжилтэд заасан эдийн засгийг тогтворжуулах, макро орчны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн нь цар тахлын хүндхэн үеийг туулах, эдийн засгийн сэргэлтийг дэмжихэд чухал нөлөө үзүүлсэн. /Зураг 5/

Зураг 5. “Зээлийн хүүг бууруулах стратеги 2020-2023” хэрэгжилт 65% байна.



Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Зээлийн хүүгийн эх үүсвэрийн зардлыг бууруулах, зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг, маргааныг зардал багатай шийдвэрлэх чиглэлээрх эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд арга хэмжээнүүдийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Дээр нь банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгох чиглэлд авч хэрэгжүүлэх хууль, эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд дутмаг ажиллажээ.

Банкны салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, зээлийн хүүг бууруулах чиглэлд хөтөлбөр, арга хэмжээнүүдийг төрийн зүгээс авч хэрэгжүүлж буй хэдий ч ямар үр дүнд хүрэх, ямар байгууллага түүнийг хариуцах, аль үеийг суурь түвшин болгон авч хэрэгжүүлэх, хэрхэн тухайн төсөл, хөтөлбөрийг үр ашигтай хэрэгжсэний үнэлэх нь ойлгомжгүй байна.

3. 2025 оны хүлээлт

3.1 Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал

Дэлхийн эдийн засагт цар тахлаас улбаатай нийлүүлэлтийн сүлжээний доголдол, худалдааны харилцааг дахин тогтооход гарч буй хүндрэл бэрхшээл, удаан хугацаанд үргэлжилж буй геополитикийн асуудлууд нь дэлхийн эдийн засаг удаашрахад нөлөөлж байна. Дээр нь цаг уурын нөхцөл байдал тэр дундаа үеэр, хэт их халалт, байгалийн гамшигт үзэгдэл ойр ойрхон тохиож байгаа нь эдийн засаг удаашрахад нөлөөлөх болжээ.

Олон улсын валютын сан (ОУВС)-гийн судлаачдын төсөөллөөр 2025 онд дэлхийн эдийн засгийн өсөлт өмнөх жилийн төсөөлөлтэй ижил байхаар хүлээгдэж байна. Тухайлбал, 2024 онд 3.2 хувиар өсөхөөр хүлээгдэж буй бол 2025 онд мөн адил 3.2 хувиар өснө. Ийнхүү хэвээр хадгалагдахад АНУ-ын эдийн засгийн төсөөлөл сайжирч, нөгөө талдаа хөгжингүй Европын орнуудын төсөөлөл буурчээ.

Хятад улсын үл хөдлөх хөрөнгийн салбарын хямрал гүнзгийрвэл олон улсын худалдаанд томоохон байр суурь эзэлдэг тул хэрэглэгчдийн итгэлийг сулруулж, дэлхийн эдийн засагт сөрөг үр нөлөө үзүүлж болзошгүй.


Цаашлаад дэлхийн инфляц буурч буй хэдий ч санхүүгийн зах зээлийн гэнэтийн хэлбэлзэл, түүхий эдийн үнийн өсөлт, геополитикийн хурцадмал байдал зэрэг эрсдэлүүд хэвээр байна.

Дэлхий даяар инфляц буурсан нь Төв банкнууд, тэр дундаа Америкийн Холбооны Нөөцийг бодлогын хүүгээ бууруулахад түлхэц өгч, хэрэглэгчдийг дэлгүүр хэсэхэд хүргэдэг. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн нь ирэх жилүүдэд дэлхийн эдийн засагт хэрхэн нөлөөлөх талаар эдийн засагчид тооцоолол хийсээр байна.

Худалдааны тариф нэмэгдэх хүлээлт байгаа нь өсөлтийг төсөөллийг бууруулж, инфляцын төсөөллийг өсгөж байна. Иймд АНУ-ын бодлогын хүү өмнө төсөөлж байснаас багаар буух хүлээлтийг үүсгэлээ.

Мөн АНУ-ын тарифын нэмжээ нэмэгдэх магадлал өндөр байгаатай холбоотойгоор Хятад улсын эдийн засгийн өсөлтийн төсөөллийг шинжээчид бууруулж байна. Хятад дотоодын нөхцөл байдлаас, тухайлбал улсын үл хөдлөхийн салбарт гарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн хэрэглээ буурч байгаагаас шалтгаалан эдийн засгийн нөхцөл байдал удааширч байгаа.

Зураг 6. Дэлхийн голлох улсуудын эдийн засгийн сэргэлт харьцангуй удаан байна.



Эх сурвалж: Дэлхийн банк

Дээр нь Хятад улсын экспорт болон импортын хэмжээ буурах төлөвтэй байгаа нь тус улсаас худалдааны хувьд хараат улсуудын хувьд ихээхэн хүндрэлийг дагуулах эрсдэлтэйгээс гадна нийлүүлэлтийн сүлжээд доголдох үүсгэх, цаашлаад дэлхийн эдийн засгийн сэргэлтэд сөргөөр нөлөөлөх төлөвтэй байна.

Европын төв банк үнийн өсөлтийг хязгаарлах үүднээс бодлогын хүүгээ эрчимтэй өсгөсөн шийдвэрүүдийн нөлөө нь Евро бүсийн эдийн засгийн өсөлт, санхүүгийн зах зээлд хүчтэй илэрч, улмаар эдийн засгийн өсөлт удаашраад байсан. Гэвч 2024 он гарсаар үйлчилгээний салбарт гарч буй эерэг өөрчлөлтүүд нь тухайн бүс нутгийн эдийн засаг аажмаар сэргэх хүлээлтийг буй болгож байна.

Томоохон эдийн засагтай улсуудын төв банкнууд бодлогын хүү аажмаар буух хүлээлттэй, зээлийн хүү буурах төлөвтэй байгаа хэдий ч банкнуудын эх үүсвэр татах зардал хэсэг хугацаанд өндөр хэвээр хадгалагдах төлөвтэй байна. Учир нь банкны салбарын өрсөлдөөн өндөр, харилцагчдын хувьд хадгаламжийн хүү өндөр байх хүлээлттэй, байгаагаас гадна олон төрлийн санхүүгийн хэрэгсэл хурдацтай хөгжиж буй зэргээс шалтгаалан ихэнх банкнуудын хувьд харилцагчдаа тогтвортой байлгах үүднээс өндөр хадгаламжийн хүү амлахаас өөр аргагүй байдалд хүрчээ. Тухайлбал, Европын банкнууд хадгаламжийн хүүг нэн яаралтай бууруулах арга хэмжээ авч байгаа бол Азийн улсууд тэр дундаа Ази номхон далайн бүс нутгийн орнуудын банкнууд зээлийн хүүгээс олох ашгийг нэмэгдүүлэх үүднээс өндөр хүүтэй хадгаламжийг санал болгосон хэвээр байна.

Ийнхүү макро эдийн засгийн дээрх нөхцөл байдалд, зээлийн хүүгийн зардал өндөр үед иргэдийн зээлийн эрэлт нэмэгдэж, зээлийн тасралтгүй өсөлт ихэнх улсуудад ажиглагдлаа. Тухайлбал, холбооны нөөцийн банкны зээлийн судалгаанаас харахад АНУ-ын банкнууд бүхий л төрлийн зээлд тавигдах шаардлагыг чангаруулсан хэдий ч зээлийн өсөлт харьцангуй өндөр байжээ. Цаашид ч эдийн засгийн тодорхой биш байдалтай холбоотойгоор барьцаа хөрөнгийн үнэ цэнэ буурах, зээлийн чанаргүйдэл нэмэгдэж болзошгүй гэсэн хүлээлттэй байгаа тул

банкнууд зээлийн нөхцөлийг сулруулахгүй байх төлөвтэй гэдгийг харуулсан. Энэ нь эдийн засгийн салбаруудыг дэмжсэн зээл олголт буурах, өрхийн хэрэглээг дэмжсэн зээл олголт буурах хүлээлтийг үүсгэж байгаа бөгөөд эдийн засаг төсөөлснөөс удаанаар өсөх эрсдэлийг дагуулж байгаа нь харагдаж байна.

Мөн сүүлийн жилүүдэд банкнууд цаг уурын өөрчлөлттэй холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь зээлийн эрэлт болон шаардлагад чухал нөлөө үзүүлэх болсон. Банкнууд байгаль, нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг хэмжих шаардлагыг тавьж байгаа нь зээлийн шалгуурууд нэмэгдэж байгаа нь зээлд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх төлөвтэй байгаа талаар Европын банкны зээлийн судалгаанд онцолсон байдаг. (ECB)

Ийнхүү хадгаламжийн хүү өндөр, бодлогын хүү буурах төлөвтэй, зээлийн шаардлага улам чангарах төлөвтэй байгаа нь банкнуудын хүүгээс олох цэвэр ашгийг бууруулах хүлээлтийг буй болгож байна.

Банкнуудын хүүгээс олох цэвэр ашиг буурах төлөвтэй байгаа нь нөгөө талаас банкнууд хүүгийн бус орлогыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах хэрэгцээ шаардлагыг үүсгэжээ. Иймээс ч банкнуудын хувьд зардлыг тодорхой хэмжээнд буулгах, өрсөлдөх чадвараа хадгалж үлдэхийн тулд технологид хөрөнгө оруулалт ихээр хийх болсон. Дээр нь хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжилгээ, цахим аюулгүй байдлыг хангаж чадах авьяаслаг ажилчдыг ажилд авах, энэ чиглэлд ажиллах боломжтой хүний нөөцийг бүрдүүлж байна.

Банкнууд 2023 оны эхний хагсаас эхлэн зээл эрсдэх магадлал өндөр гэж үзэн зээлийн эрсдэлийн санг нэмэгдүүлж эхэлжээ. Тухайлбал, 2023 оны 2 дугаар хагаст АНУ-н топ 10 банкны хувьд зээлийн эрсдэлийн санг өмнөх жилийн мөн үеэс 26 хувиар нэмэгдүүлсэн. Учир нь инфляц өндөр, мөнгөний хатуу бодлого цаашид ч үргэлжлэх төлөвтэй байгаа тул хэрэглэгчдийн хувьд зээл эргэн төлөхөд хүндрэл учирч болзошгүй гэсэн үндсэн шалтгаантай байжээ.

Томоохон банкнууд эдийн засгийн богино хугацааны шокийг даван туулахад хангалттай хэмжээний хөрвөх чадвар болон хөрөнгийн нөөцтэй байгаа талаар Холбооны нөөцийн банк,

Европын төв банк, Английн төв банкны судалгаануудаас тус тус харж болохоор байна.

Сүүлийн жилүүдэд банкны секторт АНУ-н болон Хятад улсын банкнууд үйл ажиллагааны чиглэл, хөрөнгийн хэмжээгээр томоохон байр суурь эзлэх болсон. Дээр нь дараагийн 10 жилд Энэтхэг улс, дундад Азийн улсуудын банкнууд хөрөнгийн хэмжээгээр дэлхийн топ 100 банкны эгнээнд нэгдэх хүлээлтийг үүсгэж байна.

Энэтхэг улсын эдийн засгийн хэмжээ тэлэхийн хэрээр, тухайн бүс нутагт оруулж буй хөрөнгө оруулалт нэмэгдэж үүнийг дагаад тус улсын банкнуудын хэмжээ асар хурдацтайгаар хөрөнгийн хэмжээгээр нэмэгдүүлж буй хэдий ч хараахан олон улсад үйл ажиллагаа явуулах боломж бүрдээгүй байна.

Бүс нутгийн хэмжээг хамарсан геополитикийн тогтворгүй, хурцадмал байдал нь 2024 оноос улам бүр нэмэгдэж цаашдын дэлхийн эдийн засгийн нөхцөл байдалд тодорхой бус байдлыг үүсгэж тэр хэмжээгээр эрсдэлийг тодорхойлох боломжгүй болгож байна.

Геополитикийн эрсдэл, түүнээс үүдэлтэй тодорхой бус байдал нь түүхий эдийн үнэ болон хөрш орны эдийн засгийн нөхцөл байдлаас шууд хамааралтай манай улсын хувьд хамгийн томоохон эрсдэлт хүчин зүйл юм.

Геополитикийн хувьд дараах эрсдэлүүд манай улсын эдийн засагт шууд болон шууд бус замаар нөлөөлөх эрсдэлтэй байна. Үүнд:

- * 2022 оны эхнээс үүдэлтэй ОХУ-Украины мөргөлдөөн одоог хүртэл үргэлжилж буй бөгөөд энэхүү мөргөлдөөнийг зогсооход хүчирхэг эдийн засагтай улс орнууд зэвсэг нийлүүлэх эсхүл эдийн засгийн хориг тавих зэрэг арга хэмжээнүүдийг тасралтгүй авч байгаа нь дэлхийн нийлүүлэлтийн сүлжээ доголдох, цаашлаад мөргөлдөөн улам олон улсыг хамрах эрсдэл өндөр байна.
- * 2023 онд Гоza хотод эхэлсэн Израил болон Хамаас бүлэглэлийн хоорондын зэвсэгт мөргөлдөөн одоог хүртэл дуусаагүй бөгөөд Ойрх Дорнодын бүс нутгийг хамарсан геополитикийн тодорхой бус байдлыг улам бүр нэмэгдүүлж байна. Цаашид уг нөхцөл байдал даамжирснаар тухайн бүс нутгаар

дамжин өнгөрдөг хүнсний бүтээгдэхүүн, газрын тосны нийлүүлэлт тасалдах, тээврийн зардал болон бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх эрсдэл өндөр байна.

- * АНУ болон БНХАУ-ын хоорондын технологийн өрсөлдөөн, улс төрийн зөрчилдөөн болон худалдааны дайны асуудлууд нь дэлхийн эдийн засагт мөн л тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна.

Ийнхүү дээрх тодорхой бус байдлууд нь манай улсын эдийн засгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлөх, цаашлаад эрчим хүч тасалдах, шатахууны үнэ нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавруудыг үүсгэхээс гадна тогтвортой өсөх боломжийг хязгаарлах эрсдэлтэй байна.

3.2 Монгол Улсын эдийн засгийн төлөв

Эдийн засгийн өсөлт 2025 онд өмнөх оноос өндөр байна гэсэн хүлээлт байна. 2025 онд Хятад улсын нүүрсний хэрэглээ буурч, үнэ буурах эрсдэлтэй байгаа хэдий ч манай улсаас авч буй нүүрсний тоо хэмжээ буурахгүй байх хүлээлтийг үүсгэснээс гадна нүүрснээс бусад уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт нэмэгдэхтэй холбоотой уул уурхайн салбарын өсөлт харьцангуй тогтвортой байх төлөвтэй байна.

2025 оны төсөвд тусгаснаар уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэд бүтцийн ажлуудыг нэлээдгүй хийгдэхээр байгаа нь тус салбарыг дагасан тээвэр, худалдаа үйлчилгээний салбарын өсөлтөд эергээр нөлөөлөхөөр байна.

Засгийн газар болон Монголбанкны зүгээс хөдөө аж ахуйн салбарыг дэмжих, уул уурхайн бус гаралтай түүхий эдийн экспортыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүд нь тухайн салбарын сэргэлтийг дэмжсэнээр 2025 онд эдийн засаг 6.5%-аар өсөх хүлээлтийг буй болгоод байна.¹

“Төсвийн түүхэн тэлэлт нь эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх хэдий ч тодорхой хэмжээний эрсдэлийг дагуулж байна”

Эрэлт, нийлүүлэлтийн гаралтай хүчин зүйлсээс шалтгаалан инфляц тасралтгүй өсөх төлөвтэй. Хэдий инфляцын түвшин тогтворжиж 2024 оны 9 дүгээр сарын байдлаар 6.7%-д хүрсэн ч ирэх онд төрийн албан хаагчдын цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан 6%-аар нэмэгдүүлэхээр байгаа нь өрхийн хэрэглээг

¹ Олон улсын байгууллагууд болон Монгол банк, Сангийн яам болон бусад таамаглал гаргаж буй байгууллагуудын дундаж.

тэлэх, цаашлаад бусад салбарын суурь цалингийн өсөлтийг өдөөхөөр байна.

Ийнхүү мөнгөний болон төсвийн зөөлөн бодлого зэрэг явах нь дотоод эрэлтийг нэмэгдүүлж, эдийн засгийн идэвхжилийг өрдөж улмаар эрэлтийн гаралтай хүчин зүйлс инфляцын өсөлтийг дэмжих эрсдэлтэй байна.

Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал тодорхой бус, геополитикийн асуудлууд үргэлжилж байгаа нь манай улсын импортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэд нөлөөлөх, мөн цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан хөдөө аж ахуйн салбарын уналт үргэлжилбэл хэрэглээний сагсны гол хэсгийг бүрдүүлэгч хүнсний үнэ нэмэгдэж нийлүүлэлтийн гаралтай инфляцыг нэмэгдүүлэх эрсдэлтэй.

Төсвийн хэт тэлэлт нь импортын бараа бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлж төлбөрийн тэнцэл дээр дарамт болох цаашлаад валютын ханш тогтворгүй байх эрсдэлийг дагуулж байна.

Эдийн засгийн нөхцөл байдал цар тахлын үеийнхээс сайжирсан хэдий ч гадаад, дотоод нөхцөл байдлаас шалтгаалан инфляцын түвшин өндөр байгаагаас шалтгаалан төгрөгийн бусад валюттай харьцах ханш сулрах, валютын нөөц аажмаар буурах нөхцөл байдалтай байсан хэдий ч сүүлийн нэг жилийн хугацаанд валютын ханш харьцангуй тогтвортой байлаа. Учир нь уул уурхайн гаралтай түүхий эдийн үнийн өсөлт болон тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалан манай улс сүүлийн 2 жилийн хугацаанд импортоос илүү экспортолсны нөлөөгөөр төлбөрийн тэнцэл 2022 онд 632 сая доллар, 2023 онд 666 сая долларын ашигтай гарч энэ хэмжээгээр валютын нөөц нэмэгдсэн.

Гэвч 2024 оны эхнээс төрөөс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр нь импортын бараа бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэхээс гадна иргэдийн авто машин худалдан авалт нэмэгдсэн нь төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлж 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 251 сая долларын алдагдалтай байна. Нөгөө талаас сүүлийн нэг жилийн хугацаанд манай улс руу орох гадаадын хөрөнгө оруулалт аажмаар нэмэгдэж байна.

Ирэх жилд төсвийн хэт их тэлэлт болон томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгасны нөлөөгөөр импортын бараа бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэх, энэ хэмжээгээр төлбөрийн тэнцэл болон валютын нөөцөд дарамт учрах, цаашлаад валютын ханш тогтворгүй байх эрсдэлийг дагуулж байна.

Аж ахуйн нэгж болон иргэдийн зээлийн өсөлт 2025 онд өндөр хэвээр байхаар байна. Учир нь МУ-ын төсөв 2025-д уул уурхайн салбар, түүнийг дагасан тээвэр, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтийг хадгалахад анхаарч, мөн барилга, боловсруулах болон ХАА-н идэвхжилийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг тусгажээ.

Дээр нь төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр болон нийгмийн халамжийн тэтгэврийг 6%-аар нэмэгдүүлэхээр тооцож шаардлагатай зардлыг 2025 оны төсвийн төсөлд тусгасан нь хэрэглээ үргэлжлэх тэлэх, хэрэглээг дэмжсэн зээлийн эрэлт өндөр хэвээр хадгалагдах хүлээлтийг үүсгэлээ.

2025 онд Монгол Улс томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, цалин тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэхээр тусгасан байгаа нь төлбөрийн тэнцэл болон валютын ханшид дарамт учруулж тэр хэмжээгээр банкны салбарын эх үүсвэр долларжих, эх үүсвэрийн зардал буурахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

МУ-ын зээлжих зэрэглэл тогтвортой, нэмэгдсэн хэдий ч дээр дурдсан эдийн засгийн хүндрэлүүд учрах эрсдэл өндөр байгаа тул гадаадын санхүүжилт татахад ихээхэн нухацтай хандах шаардлагатай болохыг харуулж байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тэлэлт нь бодлогын хүүг бууруулах орон зайг хумьж зээлийн хүү буурахгүй байх хүлээлтийг буй болголоо. Эх үүсвэрийн зардал аажмаар буурч байгаа нь ашигт ажиллагаанд эергээр нөлөөлөх боловч эрэлтийн гаралтай инфляцын дарамт өндөр байгаа тул хүү өсөж, хүүгийн дахин үнэлгээний эрсдэл банкнуудын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг дагуусан хэвээр байна.

3.3 Хууль эрх зүйн өөрчлөлт

Өмнөх жилүүдэд Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан эдийн засгийн хүндхэн үеийг даван туулах, эдийн засгийн сэргэлтийг дэмжих, нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд түлхүү анхаарлаа хандуулсаар иржээ.

Банкны салбарын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны сайжруулах, хяналт зохицуулалтын орчин олон улсын жишигт нийцүүлэх, банкны салбарын эх үүсвэрийн зардлыг бууруулах замаар зээлийн хүүг буурахад чиглэсэн хууль, эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг ирэх 2025 онд шат дараатайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Төрөөс мөнгөний бодлогын талаарх баримтлах үндсэн чиглэл 2025 онд эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд тогтвортой хадгалах, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх хүрээнд инфляцын түвшинг тогтвортой хадгалах, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш эдийн засгийн суурь хүчин зүйлстэй нийцтэй байхад чиглэсэн бодлогын арга хэмжээг авахаар төлөвлөжээ.

Уур амьсгалын эдийн засаг, санхүүгийн секторт үзүүлэх нөлөөг тооцох, учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, улмаар бодлогын хариу арга хэмжээ авахын тулд нэн түрүүнд нарийвчилсан тоон мэдээллийг цуглуулах түүнд тулгуурлан уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийн санг үүсгэх, ногоон зээлийн үр дүнг хэмжих тогтолцоог хөгжүүлэх, банкны салбарын уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн шинжилгээний аргачлалыг боловсруулан, туршилтын тооцоог хийхээр тусгажээ.

Дэлхий нийтэд техник, технологи хурдацтай хөгжихийн хэрээр төлбөрийн систем болон зээлийн мэдээллийн үйлчилгээг технологийн дэвшилтэй уялдуулах, цаг үедээ нийцсэн байдлаар хяналт зохицуулалтын орчныг бүрдүүлэхэд анхаарч ажиллах, санхүүгийн салбарын дэд бүтцийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, түүнд шаардлагатай зохицуулалтын орчны уялдаа холбоо, давхардлыг арилган шинэ технологид суурилсан төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг дэмжих, зээлийн мэдээллийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад анхаарч ажиллах талаар оруулж өгсөн байна.

Зураг 7. “Эх үүсвэрийн зардлыг бууруулахад чиглэсэн хууль, эрх зүйн шинэчлэлийг хийснээр зээлийн хүү буурах боломжтой.

Хуулийн өөрчлөлт

- ☐ Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт:
 - Холбогдох этгээдийн тодорхойлолт
 - Банкны тухай хуулийн 36.1 дэх хэсгийн хувь хэмжээг нэмэгдүүлэх.
 - 17.4 дэх хэсэгт заасан хязгаарлалтад зөвхөн "Энгийн болон давуу эрхийн хувьцаа"-г хамруулах
 - Хувьцаа эзэмшигч хуулийн шаардлага хангаагүйн хариуцлагыг банк хүлээдэггүй байх
- ☐ Зээлийн мэдээллийн тухай хууль.
- ☐ Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль
- ☐ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
- ☐ Иргэний хууль
- ☐ Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль (шинээр батлуулах)
- ☐ Актив удирдлагын тухай хууль
- ☐ Үл хөдлөх салбарын хамтын хамтын хөрөнгө оруулалтын сангийн хууль (REIT)
- ☐ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

Шаардлагатай хууль эрх, зүйн өөрчлөлтүүд

- ☐ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам (Е КуС ийн зохицуулалт, Эцсийн өмчлөгчийн 33 хувь 25 хувь болгож өөрчлөгдөх. Мөн Үй олноор зэвсэг дэлгэрүүлэхийн талаар ойлголтыг нэмж өгч байна)
- ☐ ICAAP, ILAAB -ийн журам батлагдах
- ☐ Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журам (Ногоон эх үүсвэр, ногоон зээлтэй холбоотой зохицуулагч байгууллагын хязгаарлалтын хувь хэмжээнд холбогдох өөрчлөлтийг оруулах)

4. Шилжилт

Өмнөх хэсгүүдэд МУ-ын банкны салбарын санхүүгийн үзүүлэлт болон хууль, эрх зүйн орчны өөрчлөлтүүдийг харуулахын зэрэгцээ манай улсын эдийн засгийн нөхцөл байдал болон дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлын төлөв байдлыг харуулсан. Энэ хэсэгт банкны салбарын тренд өөрчлөлт хэрхэн шилжиж буйг харуулахыг зорилоо. Эхний хэсэгт тогтвортой санхүүжилттэй холбоотой гарч буй тренд өөрчлөлтүүд, хоёр дахь хэсэгт технологи болон зохицуулалттай холбоотой гарч буй шилжилтүүд, гурав дахь хэсэгт хүний нөөцтэй холбоотой гарч буй трендийг харуулах болно. .

Тогтвортой санхүүжилтийн хүрээнд:

Сүүлийн жилүүдэд цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг бууруулах, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх замаар тогтвортой хөгжилд хүрэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авахад санхүүгийн байгууллагууд тэр дундаа банкнууд болон зохицуулагч байгууллагууд ихээхэн анхаарал хандуулсаар ирсэн. Банкнуудын хувьд зах зээлийн орчин, хөрөнгө оруулагчдын чиг хандлагад тулгуурлан өөрийн стратеги төлөвлөгөөг тогтвортой өсөлтийн зарчмуудтай уялдуулан өрсөлдөх чадвараа дээшлүүлж байна.

Байгаль орчинд ээлтэй тогтвортой ногоон санхүүжилтийг дэмжих үүднээс өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээг нөхөн сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй дэд бүтэц болон электрон машин, тоног төхөөрөмжид чиглүүлэхэд ихээхэн анхаарч байна. Дээр нь уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг тооцох, үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахын зэрэгцээ технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй ажлын байрыг буй болгох, цаасны хэрэглээг багасгах зэрэг үйл ажиллагааг өөрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх болжээ.

Нийгмийн хариуцлагатай тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэхийн тулд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэх боломжгүй бүлгийн хүмүүс, орлого багатай болон орлого нь тогтворгүй хүмүүст зориулсан технологид суурилсан шийдлүүдийг нэвтрүүлсэн.

Сүүлийн жилүүдэд санхүүгийн байгууллагууд технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг эрчимтэй нэвтрүүлж орон зай, цаг хугацаанаас үл хамааран санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэх боломжийг буй болгосоор байна. Тухайлбал, эмэгтэй өмчлөгчтэй жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, залуу үеийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих, хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийг дэмжих зэрэг нийгэмд ээлтэй төслүүдийг санхүүжүүлэхэд түлхүү анхаарч байна. Дээр нь банкны ажлын байран дээрх тэгш байдал, хүртээмжтэй олон талт байдлыг дэмжих үүднээс ажилчдадаа зориулсан арга хэмжээнүүдийг тасралтгүй авч байна.

Байгууллагын санхүүгийн болон холбогдох тайлан мэдээг ил тод шударга тайлагнадаг, бизнесийн хувьд ёс зүй өндөртэй байгууллагуудыг санхүүжүүлэх замаар тогтвортой засаглалын тогтолцоог бүрдүүлэхэд ихээхэн анхаарал хандуулж байна. Дээр нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг, хөдөлмөрийн хамгааллыг дагадаггүй, засаглал тогтоогүй байгууллагуудыг санхүүжүүлэхээс татгалздаг тогтолцоо руу шилжиж байна.

Ийнхүү дээр дурдсан тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, сайжруулан ажиллахад

- 1) санхүүгийн хэрэглэгчдийн санхүүгийн мэдлэг дутмаг,
- 2) санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхэд гарч болох эрсдэлийг бүрэн тооцох боломжгүй,
- 3) технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний эко системийг бүрдүүлэх, шинээр зах зээлд нийлүүлэхэд зардал өндөртэй байна.

Технологийн шийдэл болон зохицуулалтын хүрээнд:

Сүүлийн жилүүдэд дижитал банкнууд илүү өндөр хүүтэй, уян хатан хадгаламжийн бүтээгдэхүүн санал болгож буй нь банкнуудад хадгаламж татахад илүү төвөгтэй нөхцөл байдлыг бүрдүүлсэн. Дээр нь цахим хэтэвч, данснаас данс руу төлбөр хийгдэх, QR код ашиглах зэрэг олон төрлийн төлбөрийн систем гарсан нь хэрэглэгчдэд

олон төрлийн төлбөрийн хэрэгсэл ашиглах боломж олгож байна.

Сүүлийн жилүүдэд банкны кредит картын үйлчилгээг орлох бүтээгдэхүүн, үйлчилгээ болох “одоо аваад, дараа төл” нь илүү эрчимтэй хөгжиж байна. Ийнхүү санхүүгийн бус байгууллагууд санхүүгийн салбарын уламжлалт бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож буй санхүүгийн зах зээлд тооцох боломжгүй эрсдэлийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн зээлийн эрсдэлийн талаарх тооцооллуудыг өөрчлөх хэрэгцээ шаардлага үүссэн.

Банк, финтек болон фигтекүүдийн хоорондын өрсөлдөөн нэмэгдэхээс гадна зарим талаараа харилцан хамааралтай болж байна. Ялангуяа банкнууд финтек компаниудыг өрсөлдөгч гэж харахаас илүүтэйгээр банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж буй хамтрагч гэдэг талаас харах болсон.

Өөрөөр хэлбэл санхүүгийн салбарын цаашдын чиг хандлага, ирээдүйн хөгжлийн төлөө банкнууд нь финтек компаниуд болон томоохон технологийн компаниудтай хамтран бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлыг бууруулж, хүртээмжтэй үйлчилгээг хүргэх, харилцагчийн итгэлийг алдахгүй байх тал дээр ихээхэн анхаарч ажиллаж байна.

Үүний зэрэгцээ технологийн шинэчлэл, өөрчлөлт нь харилцагчийн амьдралын хэмнэл, дадалд нөлөөлж илүү үр ашигтай, зардал багатай, хурдан шуурхай санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг авах хүлээлтийг үүсгэсэн. Дээр нь харилцагчийн зан төлөв, хэрэглээний чиг хандлагын талаарх олон төрлийн мэдээллийг сошиал медиа, технологийн платформ зэргээс авч боловсруулан тухайн харилцагчдад тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож буй нь харилцагчид шууд өөрийн гар утсаар дамжуулан өөрт тохирсон сонголтоо хийх боломж олгож байна.

Зураг 8. Банкны салбарт гарч буй тренд өөрчлөлтүүд.



Ялангуяа залуу харилцагчдын хувьд финтек болон технологийн компанийн санал болгож буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хэт мэдрэмжтэй байгаа нь банкнууд хэрэглэгчдээ тэдгээр компаниудад алдах эрсдэлийг дагуулж байна.

Дэлхийн ихэнх улсуудад харилцагчийн нууцыг хадгалах, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, нээлттэй шударга өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, шинээр технологид тулгуурлан гарч буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулахад чиглэсэн хууль, эрх зүйн зохицуулалтыг нэлээдгүй хийгдэхээр байна. Тухайлбал, Базел III-т тусгагдсаны дагуу эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн тооцоололд өөрчлөлт орж буйтай холбоотойгоор 2025 оны 7 дугаар сараас эхлэн АНУ-ын томоохон банкнууд хөрөнгийн хязгаарлалтыг нэмэгдүүлнэ. Энэ нь тус улсын хөрөнгийн зах зээлд нөлөөлөхөөс гадна банкнуудын зээлийн шалгуурт өөрчлөлт орох, түүнтэй холбоотой зохицуулалтууд хийгдэх хүлээлтийг үүсгэсэн.

Мөн Англи, Европ, Австрали, Өмнөд Араб, Бразил, Мексик зэрэг улсуудад нээлттэй банкны тухай зохицуулалт хэрэгжиж байгаа бөгөөд тус зохицуулалтын хүрээнд банканд байгаа тоон мэдээллийг гуравдагч этгээдэд хуваалцахтай холбоотойгоор харилцагчийн мэдээллийг хамгаалах, хадгалахад чиглэсэн эрх, зүйн зохицуулалтууд хийгдэж байна.

Санхүүгийн салбарт шинээр үүсэж буй дижитал хөрөнгө буюу крипто валютыг ашиглах, хэрэглэхтэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт хийгдэх хүлээлт байгаа бол нөгөө талаас банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын гаргаж буй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг зохицуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд ихэнх улсууд анхаарах болжээ.

Дээрх хүлээгдэж буй хууль, эрх зүйн өөрчлөлтүүд нь банкны салбарын уламжлалт бизнес загварыг өөрчлөхөөс гадна, шинээр гарч буй технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг эрчимжүүлэх, банкны салбарын хөгжлийг дараагийн шатанд хүргэх хүлээлтийг үүсгээд байна.

Хиймэл оюун ухааныг ашиглан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хурдан шуурхай, зардал багатай, хүртээмжтэй хүргэхээс гадна банкны салбарын хүний нөөцийн үр ашигтай ажиллах, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч ажилладаг болсон.

Технологийн шийдлүүд нь банкны үйл ажиллагаанд эергээр нөлөөлж буй хэдий ч ямар төрлийн мэдээллийг ашиглах, хэрхэн тэр мэдээлэлд тулгуурлан үр дүнтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдад хүргэх нь томоохон сорилт хэвээр үлдээ. Дээр нь сүүлийн жилүүдэд банкнууд технологийн компаниудтай хамтран ногоон санхүүжилт, карбон хэмжилтийг үр ашигтай хийх шинэлэг технологийг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг олон арга хэмжээ авч байна.

Хүний нөөцтэй холбоотой гарч буй өөрчлөлтийн хүрээнд:

Эцэст нь банкнуудын хувьд технологийн эрэн үед түүнтэй хөл нийлүүлэн ажиллах авьяастай чадварлаг хүний нөөцийг тогтоох, урт хугацаанд үр ашигтай ажиллуулах тал дээр анхаарч ажиллаж байна.

Банкнуудын хувьд технологийн олон төрлийн шийдэл бүхий нөхцөлд ажиллаж чадах ажилтныг өөр салбараас олж, өөрийн банканд ажиллуулах эсхүл өөрийн хүний нөөцийг хиймэл оюун ухааны, chatgpt ашиглан бүтээмжээ нэмэгдүүлэх, үр ашигтай ажиллахад нь сургах, хөгжүүлэхэд анхаарлаа хандуулах болсон.

Нөгөө талаас банкны ажилтнууд нь өөрийн мэдлэгийг улам бүр дээшлүүлэн харилцагчдад тохирсон, үр ашигтай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхэд анхаарах хэрэгцээ шаардлагатай тулгарч байна.

Өөрөөр хэлбэл банкны ажилтнууд нь технологийг өдөр тутмын ажилдаа ашиглах, бүтээмжээ нэмэгдүүлэх, өөрийн цагийг үр ашигтай ашиглахаас гадна өөрийгөө хөгжүүлэхэд анхаарлаа хандуулах замаар өөрийн үнэ цэнийг бүтээж, илүү урт хугацаанд өрсөлдөх чадвартай байх тал дээр анхаарах шаардлагатай болж байна.

5. Банкны салбарын эрсдэлүүд

• Гадаад орчны эрсдэл

Геополитикийн маргаан, улсуудын хоорондын зөрчилдөөн намжихгүй байх нь гадаад эдийн засагт улам бүр тодорхой бус байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Дээр нь АНУ болон Хятад улсуудын хооронд худалдааны дайн дахин үргэлжлэх, Хятад улсын үл хөдлөх хөрөнгийн салбар, аж үйлдвэрийн салбар удаашралд орох нь манай улсын эдийн засагт сөргөөр нөлөөлөх эрсдэл өндөр байна. Ингэснээр уул уурхайн салбар, түүнийг дагасан тээвэр, худалдаа болон үйлчилгээний салбарын удаашрал нь банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, зээлийн эрсдэлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй.

Хятад улсын уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний нөлөөгөөр сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх, түүхий нүүрсний эрэлт багасаж улмаар үнэ буурах нь манай улсын эдийн засагт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Ийнхүү төсвийн орлого тасалдаж иргэдийн цалин, тэтгэвэр доголдох, улмаар иргэдийн чанаргүй зээл нэмэгдэх эрсдэлийг дагуулж байна.

• Зах зээлийн эрсдэл

МУ-ын засгийн газрын 2024-2028 үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжиж, дотоодын хэрэгцээг хангахад чиглэсэн хөтөлбөрүүд болон иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрийн дэмжлэгийг ирэх 2025 онд үргэлжлүүлэхээр тусгасан.

Экспортын орлого тасалдах, төлөвлөсөн хөрөнгө оруулалт хийгдэхгүй зэрэг эрсдэлүүд нь банкны зээлийн үйл ажиллагаанд доголдол учруулах, зээлдэгчдийн зээл чанаргүй болох зэрэг эрсдэлүүдийг дагуулж байна.

Төсвийн хэт их тэлэлтийн улмаас эрэлтийн гаралтай инфляц нэмэгдэх, түүнийг дагаад бодлогын хүүг буурахгүй өндөр түвшинд хадгалдах нь эх үүсвэрийн зардал буурахгүй байхад нөлөөлж энэ эргээд банкны цэвэр хүүгийн маржин болон хөрөнгө оруулалтын багцад нөлөөлөх эрсдэлийг дагуулж байна.

Ирэх 2025 оны төсвийн төсөлд дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх, цалин тэтгэвэр нэмэх, засгийн газрын хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүд тусгагдсан. Төсвийн тэлэлт нь импортын бараа бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлж төлбөрийн тэнцэл, валютын ханшид ирэх дарамтыг нэмэгдүүлэх хүлээлтийг үүсгээд байна. Ийнхүү төгрөг суларч эх үүсвэрийн долларжилт явагдах, гадаадын эх үүсвэр татах өртөг үнэтэй болох зэрэг эрсдэлүүдийг дагуулж байна.

Финтек зээлийн үйлчилгээ үзүүлэгч, хувааж төлөх нөхцөл бүхий онлайн худалдааны үйлчилгээ, одоо аваад дараа төлөх нөхцөл бүхий төлбөрийн үйлчилгээ эрчимтэй хөгжиж буй нь сайн боловч зээлдэгчийн өрийн дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Хэрэв эдийн засгийн нөхцөл байдал таагүй болбол эдгээр иргэд зээлээ төлж чадахгүй байх эрсдэл өндөр байна.

• Засаглал, дотоод эрсдэл

Банкны шинэчлэлийн хөтөлбөрийн дахин хэрэгжүүлэх, зээлийн хүү буулгах стратегийг шинээр батлахтай холбоотой холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах нь банкны ашигт ажиллагаа, үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэлтэй байна.

Базел III-ийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх, хөрвөх чадварын харьцааг өөрчлөх зэрэг арга хэмжээнүүдийг авах нь банкны ашигт ажиллагаа болон үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Хувь хүний мэдээллийг хадгалах, дамжуулахтай холбоотой мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах хууль болон кибер халдлагаас хамгаалахад чиглэсэн хууль, эрх зүйн өөрчлөлт нь банкны салбарын технологийн шинэчлэл, технологийн дэвшилд тулгуурласан үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэл байна.

Банкны салбарын дижиталжилт нь салбарын хүний нөөцийг улам л үр ашигтай, бүтээмжтэй ажиллахыг шаардаж байна. Иймд банкнууд хүний нөөцөө AI, Chat GPT болон бусад технологийг дэвшлийг ашиглахад сургах, хөгжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргахгүй бол санхүүгийн салбарт хоцрогдох, өрсөлдөөний гадна үлдэх эрсдэл өндөр.

6. Эрсдэлийг бууруулах шийдлүүд

• Эрсдэлийн менежментийг сайжруулах

Эрсдэлийг тооцох, үнэлэх ахисан түвшний эрсдэлийн загварыг олон улсын сайн туршлагад тулгуурлан боловсруулах, эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зээлийн багцыг тогтмол хянах. Гадаад, дотоод эдийн засгийн тодорхой бус байдал, хууль эрх зүйн өөрчлөлттэй холбоотой гарч болзошгүй эрсдэлийн менежментийг хэрэгжүүлж эрсдэлийн тооцоололд оруулж, эрсдэлийн үнэлгээг тогтмол сайжруулах. Дээр нь таамаглах боломжгүй гэнэтийн

Уур амьсгалын өөрчлөлт, технологийн дэвшил болон бусад төрлийн эрсдэлийг бүгдийг нь тооцох боломжийг бүрдүүлэхэд анхаарах.

• Комплайнс

Базел III-ийн стандарттай холбоотой эрсдэлийн аргачлалуудыг боловсруулах, өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч ажиллах. Тогтвортой санхүүжилтийн хүрээнд шинээр гаргаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнд ногоон угаалттай холбоотой стандарт дүрэм, журмыг боловсруулж мөрдөх.

Мөн хэрэглэгчийг цахим халдлагад өртөхөөс сэргийлэх, цахим гэмт хэрэгтэй холбоотой аливаа үйл ажиллагаанаас сэргийлэхээд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Хэрэглэгчийн мэдээллийн нууцыг хамгаалахад чиглэсэн технологийн шийдлийг нэвтрүүлэх, түүнийг зохистой хэрэглээг хангаж ажиллах.

• Төрөлжилтийг нэмэгдүүлэх

Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй дэд бүтэц, жижиг дунд бизнес эрхлэгч болон технологийн компаниудад зориулсан санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэх.

Төр болон хувийн хэвшилд байгаа хэрэглэгчийн дата мэдээллийг ашиглан тухайн хэрэглэгчдэд тохирсон олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхэд анхаарлаа хандуулах.

Санхүүгийн бусад байгууллагуудтай дата мэдээлэл солилцох, хуваалцах боломжийг бүрдүүлж тухайн хэрэглэгчийн онцлогт тохирсон санхүүгийн үйлчилгээний шийдлүүдийг санал болгох, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийн гүнзгийрлийг нэмэгдүүлэх.

• Дижитал шилжилт

Мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлд түлхүү анхаарах. Дээр нь банкны салбарын ажилчдын технологитой ажиллах, технологийн дэвшлийг ашиглан үр ашигтай ажиллах арга барицыг суулгах. Технологийн компанитай хамтрах замаар санхүүгийн хэрэглэгчдэд тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхэд чиглэсэн шийдлүүдийг ашиглахад анхаарч ажиллах нь зүйтэй байна.